



**АРХАНГАЙ АЙМГИЙН УЛСЫН
БҮРТГЭЛ СТАТИСТИКИЙН
ГАЗАР**

Аж үйлдвэр

Эрдэнэбулган

2016 он

Агуулга

Удиртгал	2
Аймгийн газарзүйн байршил, уур амьсгал	3
Аймагт бүртгэлтэй аж ахуйн нэгжийн тоо	6
Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн, борлуулалт	8
Аж үйлдвэрийн салбарын бүтээмж	9
Цахилгаан эрчим хүчний хэрэглээ	11
Тээвэр, холбооны салбар	12
Дүгнэлт	16
Ашигласан материал, ном зүй	16

Удиртгал

Аж үйлдвэрийн салбарын үйл ажиллагаа нь бусад хүчин зүйлээс илүүтэйгээр хүн амын хэрэглээ,дэд бүтцийн хөгжил,ашигт малтмалын нөөц зэргээс илүү хамааралтай юм.Гэхдээ уул уурхайн салбар нь байгалийн байршил,түүний нөөц бололцоо,техник технологийн байдлаас илүү шалтгаална гэж үзэж байна.Дэлхийн улс орнуудын нэгэн адил манай улсын эдийн засгийн хөгжилд аж үйлдвэрийн салбар нь ихээхэн чухал байр эзэлдэг салбаруудын нэг юм.

Аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлтийн хэмжээнд бүтээгдэхүүний биет хэмжээ, үнэ гэсэн хоёр хүчин зүйл нөлөөлдөг бөгөөд бүтээгдэхүүний үнийн өсөлтийн нөлөөллийг арилгаж, зөвхөн үйлдвэрлэлийн өсөлтийг тодорхойлох зорилгоор статистикийн практикт үйлдвэрлэлийн индексийг ашиглахыг зорилоо.

Тэдгээр үзүүлэлтүүдийг гаргах мэдээллийн эх сурвалж нь үйлдвэрийн газруудын сар улирал,тухайн болон өмнөх жилийн тайлан,тооллого судалгааны гол эх үүсвэр болгон ашиглаж байна. Хэд хэдэн төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж ,ажил үйлчилгээ эрхэлдэг нэгжийг тэдгээрийн дотор мэдэгдэхүйц өндөр хувийн жинтэй бүтээгдэхүүн,ажил үйлчилгээг нь үндсэн салбарт оруулдаг.Сар бүр аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг хамруулан судалдаг. Тус салбарын үйл ажиллагаа нь хүн амын хэрэглээ,дэд бүтэц болон ашигт малтмалын нөөц ,уул уурхайн газар зүйн байршлаас илүү

хамааралтай бөгөөд боловсруулах аж үйлдвэрийн салбар нь ихэнхдээ хүн амын хэрэглээг хангахад оршино.

Архангай аймгийн газарзүйн байршил, уур амьсгал

Архангай аймаг нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн төв хэсэгт буюу Хангайн уулархаг мужийн төв хэсэг уулс хоорондын Тэрхийн Цагаан нуур , Их ба Өгий нуурууд, Тамир, Орхон, Хүнүй, Хануй болон Чулуут зэрэг голын хөндийнүүдийг дамнан хамарсан удам нутагтай. Баруун талаараа Завхан, хойд талаараа Хөвсгөл, зүүн талаараа Орхон, Булган, урд талаараа Өвөрхангай, Баянхонгор аймгуудтай хиллэн оршино.

Байгалийн баялаг, ашигт малтмал:

Архангай аймгийн нутаг дэвсгэрт 2002 оны байдлаар ашигт малтмалын 26 орд, 66 илрэл, эрдэсжсэн цэг тогтоогдсон байна. Ашигт малтмалуудаас товч дурдвал:

Нүүрс: Баянцагааны орд. Ихтамир сумаас зүүн хойш 10 км-т Баянцагаан голын адагт оршдог. Нөөцийн хэмжээ 948.3 мян.тн.

Шатдаг занар: Орд нь Зүүн булаг. Хашаат сумаас зүүн урагш 25 км-т Зүүн булагийн хойд хөндийд оршдог. Занарын нөөц 53 мян.тн, нөөцөд байгаа орд.

Алт: Тус аймгийн Тариат, Булган, Цэнхэр, Жаргалант зэрэг сумдад алтны нөөц бий. Одоогоор Цэнхэр сумын Орхоны алтны ордыг ашигласан байна.

Мөнгө: Ихтамир сумын Хойт тамирын гол, Аргалант уулын баруун хажуу, Хундат уулын ар хажууд оршдог. Илрэлийн нөөц нь 29-138 тн байна.

Өнгөлгөөний чулуу: Батцэнгэл, Жаргалант, Өгийнуур сумдад өнгөлгөөний чулууны ордтой бөгөөд хэтийн төлөв нь тодорхойгүй нөөц нь хэдэн сая/ м³ байна.

Аймагт бүртгэлтэй аж ахуйн нэгж байгууллагын тоо

Тус аймгийн хувьд 2015 онд үйл ажиллагаа эрхэлж байгаа 991 аж ахуй нэгж. ХАА, агнуурын чиглэлээр 130, боловсруулах чиглэлээр 102, цахилгаан хий үйлдвэрлэл 2, усан хангамж 1, барилга 32, бөөний болон жижиглэн худалдаа 285, зочид буудал зоогийн газар 30, тээвэр, агуулахын аж ахуй, холбоо 13, санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа 8, үл хөдлөх хөрөнгө, түрээс бизнесийн үйл ажиллагаа 7, боловсролын салбарын үйл ажиллагаа 85, эрүүл мэнд нийгмийн халамжийн үйл ажиллагаа 33, нийгэм бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээний чиглэлээр нийт 33, Мэргэжлийн болон шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулдаг 72 аж ахуй нэгж бүртгэгдсэн байна.

Үндсэн ойлголт, тодорхойлолт:

Бүтээгдэхүүн гэж бусад бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэлтэд завсрын хэрэглээний орц хэлбэрээр, эсвэл хүн амын эцсийн хэрэглээ болж ашиглагдах зорилгоор үйлдвэрлэлийн үр дүнд бий болсон биет зүйлийг;

Нийт үйлдвэрлэлт гэж аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн өөр нэгж байгууллагын хэрэглээнд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулан үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний нийт хэмжээг;

Индекс гэж тухайн үзэгдлийн тодорхой хугацааны өөрчлөлтийг харуулсан харьцангуй хэмжигдэхүүнийг;

Суурь үе гэж үзэгдлийн өөрчлөлтийг судлах зорилгоор сонгож авсан тулгуур үеийг;

Тайлант үе гэж өнөөгийн үйл ажиллагааны үр дүнг харуулсан тодорхой хугацааг;

Мэдээллийн эх үүсвэр

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний биет хэмжээг нэгтгэн гаргах мэдээллийн эх үүсвэр нь “Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн сарын мэдээ” (АҮ-1) байна. Мөн аж ахуйн нэгж байгууллагын жилийн эцсийн мэдээ (ААНБ-1, ААНБ-2).

Хамрах хүрээ, ангилал

Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал болон Бүтээгдэхүүн, үйлчилгээний нэгдсэн ангиллыг ашиглана. Аж үйлдвэрт хамрагдах үйл ажиллагаа нь Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллын дагуу уг салбарт үйлдвэрлэгдэж буй бүтээгдэхүүн нь бүтээгдэхүүн, үйлчилгээний нэгдсэн ангиллын дагуу тус тус ангилагдана.

Аймагт бүртгэлтэй аж ахуйн нэгж байгууллагын тоо

Аймгийн хэмжээнд 2015 онд 1256 аж ахуйн нэгж бүртгүүлснээс үйл ажиллагаа явуулж байгаа 991 аж ахуйн нэгж байгууллага, үйл ажиллагаа явуулаагүй 265 аж ахуйн нэгж байгууллага байна.

Хуулийн этгээд аж ахуйн нэгж байгууллагын тоо

Хүснэгт 1

	2014	2015
Бүгд	1103	1256
Үйл ажиллагаа явуулж байгаа	830	991
Үйл ажиллагаа явуулаагүй	273	265
Үүнээс:		
Эхлээгүй	124	106
Түр зогссон	108	117
Бүрэн зогссон	40	40
бусад	1	1

Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгийн тоо, сумаар



Үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээд, аж ахуйн нэгж байгууллагын тоо, салбарын ангилалаар

Хүснэгт 2

	2014	2015
Бүгд	830	991
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт	120	130
Боловсруулах үйлдвэр	116	102
Цахилгаан хий	4	2
Барилга	29	32
Бөөний жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засвар	220	285
Зочид буудал, зоогийн газар	37	30
Тээвэр агуулахын аж ахуй, холбоо	7	13
Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа	9	8
Үл хөдлөх хөрөнгө, түрээс бизнесийн Төрийн удирдлага, батлан хамгаалах даатгалын	57	61
Боловсролын салбарын үйл ажиллагаа	73	85
Эрүүл мэнд нийгмийн халамжийн үйл ажиллагаа	34	41
Нийгэм бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээ	100	123
Мэргэжлийн болон шинжлэх ухааны үйл ажиллагаа	46	72



Аж үйлдвэрийн нийт бүтээгдхүүн, оны үнээр, сая. Төг

Хүснэгт 3

	2012	2013	2014	2015	$\frac{2015}{2013}\%$	$\frac{2015}{2014}\%$
Нийт дүн	5111.6	5054.3	5181.3	5454.9	107.9	105.3
Хүнс, ундаа	1941.6	1542.0	1196.1	382.4	24.8	32.0
Хэвлэлийн	42.4	40.1	48.3	86.4	215.5	178.9
Цахилгаан дулаан	2449.8	2665.8	2737.9	3441.4	129.1	125.7
Мод, модон эдлэл	106.6	65.3	158.2	825.5	1264.2	521.8
Усан хангамж	466.6	563.1	639.9	209.2	37.2	32.7
Гутал, хувцас	77.3	96.2	166	182.4	189.6	109.9
Нэхмэлийн		51.6	25.3	7.1	13.8	28.1
Хуванцар бүтээгдэхүүн	22.3	26.4	205.2	315.2	1193.9	153.6
Бусад	5.0	3.8	4.4	5.3	139.5	120.5

Оны үнээр 5454.9 сая төгрөгийн бүтээгдэхүүн

үйлдвэрлэсэн нь өнгөрсөн оныхоос 5.3 хувиар өссөн байна.

Аж үйлдвэрийн борлуулсан бүтээгдхүүн оны үнээр, сая.төг


Хүснэгт 4

	2012	2013	2014	2015	$\frac{2015}{2013}\%$	$\frac{2015}{2014}\%$
Нийт дүн	5113.0	5054.0	5181.3	5454.9	107.9	105.3
Хүнс, ундаа	1941.6	1542.0	1196.1	382.4	24.8	32.0
Хэвлэлийн	43.8	39.8	48.3	86.4	217.1	178.9
Цахилгаан дулаан	2449.8	2665.8	2737.9	3441.4	129.1	125.7
Мод, модон эдлэл	106.6	65.3	158.2	825.5	1264.2	521.8
Усан хангамж	466.6	563.1	639.9	209.2	37.2	32.7
Гутал, хувцас	77.3	96.2	166	182.4	189.6	109.9
Нэхмэлийн		51.6	25.3	7.1	13.8	28.1
Хуванцар бүтээгдэхүүн	22.3	26.4	205.2	315.2	1193.9	153.6
Бусад	5.0	3.8	4.4	5.3	139.5	120.5

Тус салбарт 5454.9 сая төгрөгийн борлуулалт хийсэн нь

өнгөрсөн оныхоос 5.3 хувиар өсөв.

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний салбарын бүтэц/ Composition of industrial output



Аж үйлдвэрийн салбарын бүтээмж

Бүтээмж нь улс оронд бий болсон үйлдвэрлэл, үйлчилгээний үр ашгийн үзүүлэлт бөгөөд нэгж зардлаар хэдий хэр бүтээгдэхүүн, үйлчилгээ үйлдвэрлэж байгааг тодорхойлдог. Хөдөлмөр нь аливаа үйлдвэрлэл үйлчилгээг явуулахад зайлшгүй шаардлагатай хамгийн чухал, бодитой хэмжигдэхүйц хүчин зүйл. Хөдөлмөрийн бүтээмжийг тооцоохдоо нэмэгдэл өртгийн хэмжээг жилийн дундаж ажиллагчдын тоонд хуваана.

$$\text{Хөдөлмөрийн бүтээмж} = \frac{\text{ДНБ/нэмэгдэл өртөг}}{\text{Хөдөлмөр}}$$


Хөдөлмөрийн үзүүлэлтийг хэд хэдэн үзүүлэлтээр авч болно. Хөдөлмөрийн бүтээмж нь хөдөлмөрийг ямар хэлбэрээр авч

байгаагаас хамаарч дараах төрлүүдтэй байна.Тухайлбал: нэг ажилчинд ногдох хөдөлмөрийн бүтээмж, нэг цагт ногдох хөдөлмөрийн бүтээмж (ажилласан хүн цагаар хэмжигдэнэ), нэг өдөрт ногдох хөдөлмөрийн бүтээмж (ажилласан хүн өдрөөр хэмжигдэнэ), хөдөлмөрийн хөлсний нэгж тутамд ногдох хөдөлмөрийн бүтээмж гэх мэтчилэн ангилдаг

Хүснэгт 5

Салбар	2011	2012	2013	2014	2015
Аж үйлдвэрийн нэмэгдэл өртгийн хэмжээ	30802.0	33575.7	48022.5	63026.3	53553.0
Аж үйлдвэрийн салбарын ажиллагсадын тоо	304	332	407	445	486
Хөдөлмөрийн бүтээмж	101.3	101.1	117.9	141.6	110.2

Аж үйлдвэрийн салбарын хөдөлмөрийн бүтээмж



Цахилгаан эрчим хүчний хэрэглээ


	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015
Нөөц - бүгд	18.0	20.5	21.0	23.5	25.9	22.0	30.6	29.7	29.7
Үйлдвэрлэсэн									
Хэрэглэсэн	18.0	20.5	21.0	23.5	25.9	22.0	30.6	29.7	29.7
Үүнээс:									
аж үйлдвэр	1.2	1.2	1.2	1.2	1.2	1.2	0.8	0.9	2.6
барилга	0.5	0.3	0.4	0.4	0.4	0.3	0.9	1.1	3.4
тээвэр									
холбоо	1.3	1.3	1.4	1.5	0.2	0.3	0.3	0.4	0.9
хөдөө аж ахуй									
худалдаа	0.2	0.2	1.4	1.5	1.5	1.8	2.0	2.4	3.8
орон сууц, НАА	5.9	7.6	7.9	8.6	10.0	11.6	13.0	11.2	12.4
үүнээс: хүн амд	5.9	7.6	7.9	8.6	10.0	11.6	13.0	11.2	12.4
бусад	0.3	3.0	4.0	5.4	6.9	0.8	5.9	7.0	4.6
Шугамын алдагдал	4.5	5.2	4.7	4.9	5.7	5.9	7.5	6.5	1.8

Цахилгаан станцын
дотоод хэрэглээ

0.2 0.2 0.2

Нэг хүнд ногдох

цахилгаан, квт.цаг 202.9229.3235.1258.2282.7239.4331.4320.1321.8



**Тээврийн салбарын тээсэн ачаа, ачаа эргэлт,
зорчигчдын тоо, зорчигч эргэлт**

Тээврийн салбарын статистик үндсэн үзүүлэлтүүд ачаа эргэлт, тээсэн ачаа, зорчигч эргэлт, авто машины тоо, шилжүүлсэн тонн.км ажиллагсадын тоо орлого зэрэг орно. Авто тээврийн статистик мэдээ тайланг аж ахуйн нэгж, сумаас авч нэгтгэн Үндэсний Статистикийн хороонд дамжуулдаг

Ачаа эргэлт Нийт тээвэрлэсэн ачааны хэмжээг зөөвөрлөсөн зайгаар үржүүлсэн үзүүлэлт

Зорчигч эргэлт Нийт зорчигчдын тоог тээвэрлэсэн зайгаар үржүүлсэн үзүүлэлт

Шилжүүлсэн тонн.км Тээврээр гүйцэтгэсэн олон төрөл хэлбэрийн ажил үйлчилгээг тусгай коэффициентийг ашиглан нэг нэгжид шилжүүлж тооцно.


Тээврийн салбар

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2013	2014	2015	$\frac{2015}{2013}\%$	$\frac{2015}{2014}\%$
Зорчигч эргэлт	мян.хүн.к м	19805.8	19997.4	18374.2	92.8	91.9
Зорчигчид Нийт ачаа эргэлт	мян.хүн мян.тн.км	43.1	43.3	39.8	92.3	91.9
Тээсэн ачаа	мян.тн	7347.9	10309.1	7227.5	98.4	70.1
Орлого	мян.төг	22.2	73.9	28.8	129.7	39.0
		882514.8	797259.6	659424.9	74.7	82.7

Тээврийн нийт орлого өнгөрсөн онтой харьцуулахад 17.3 хувь буюу 137.8 сая төгрөгөөр буурсан байна.

Авто техникийн улсын үзлэгт орсон авто машины тоо

	2011	2012	2013	2014	2015
Бүгд	6395	7464	8037	8378	8863
Үүнээс:					
Суудлын	2462	2816	3098	3347	3652
Ачааны	2655	3357	3810	4135	4385
Автобус	433	541	540	487	455
Цистерн		8			
Мотоцикл	670	584	404	185	112
Механизм	21	28	6	30	59
Чиргүүл	154	130	65	79	84



**Холбооны үйлчилгээний орлого, радио, телефон
цэгийн тоо**


Холбооны нийт орлого, үүнээс хүн амаас орсон орлого телефон болон радио цэгийн тоо зэрэг үндсэн үзүүлэлтийг харуулна.

Холбооны байгуулагууд 483 телефон цэг улс, хот хоорондын телефоны үйлчилгээгээр байгууллага иргэдэд үйлчилж сумдад 7 хоногт 1-2 удаа шуудан хүргэж нийт 337.5 сая төгрөгийн орлоготой ажилласан нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 2.2 хувиар нэмэгдэв. Харилцаа холбоо эрчимтэй хөгжиж байгаа өнөө үед магнай аймгийн нутаг дэвсгэр дээр үүрэн телефон холбооны таван оператор компаний салбарууд үйл ажиллагаагаа явуулж 65.5 мянга гаруй хүн гар утас хэрэглэж байна.


Холбооны салбар

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2013	2014	2015	$\frac{2015}{2013}\%$	$\frac{2015}{2014}\%$
Холбооны нийт орлого	мян.төг	280771.0	330135.2	337513.1	120.2	102.2
үүнээс хүн амаас	мян.төг	32696.8	30590.0	47552.5	145.4	155.5
Илгээлт	мян,төг	1714.2	2180.5	4634.9	270.4	212.6
Шуудангийн хайрцаг	мян,төг	89.1	3219.8	676.5	759.3	21.0
Үнэт цаас	мян,төг	19717.3	17877.0	23435.5	118.9	131.1
Телефон цэг	шир	486	476	483	99.4	101.5
Кабелийн телевиз	шир	808	863	835	103.3	96.8

Холбооны нийт орлого /сая.төг/



Кабелын телевизын тоо



Дүгнэлт

Аймгийн хэмжээнд 2015 онд 1256 аж ахуйн нэгж бүртгүүлснээс үйл ажиллагаа явуулж байгаа 991 аж ахуйн нэгж байгууллага, үйл ажиллагаа явуулаагүй 265 аж ахуйн нэгж байгууллага байна.

Тус салбарт 5454.9 сая төгрөгийн борлуулалт хийсэн нь өнгөрсөн оныхоос 5.3 хувиар өсөв.

Тээврийн нийт орлого өнгөрсөн онтой харьцуулахад 17.3 хувь буюу 137.8 сая төгрөгөөр буурсан байна.Өнгөрсөн оны мөн үеийнхээс зорчигч эргэлт, орлогын хэмжээ нэмэгдсэн нь сум, хот хоорондын тээвэрт аймгийн тээврийн эзлэх хувь нэмэгдсэнээс сайнаар нөлөөлөв

Төр засаг авч хэрэгжүүлж буй жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр олгож буй хөнгөлөлттэй зээл нь үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх оновчтой хөтөлбөр болж байна. Гэхдээ зээлийн хүрэлцээ бага, зарим нэгний үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь борлогдохгүй, чанарын шаардлага хангахгүй байгаагаас хэрэглэгчдийн хэрэгцээнд тэр болгон нийцэхгүй байна

Өөрийн аймгийн нутаг дэвсгэр дээр байгаа байгалийн янз бүрийн ашигт малтмалууд дээр тулгуурласан үйл ажиллагаа явуулах боломжтой юм. Ингэснээрээ өөрийн аймгийн хэрэглээг хангаад зогсохгүй өөр аймагт экспортлох боломж нээлттэй болно.

Тухайлбал Тариат, Хотонт, Өндөр-Улаан сумдад хүрмэн чулууны ордод түшиглэн хүрмэн блокны үйлдвэрлэлийг, Эрдэнэбулган, Хотонт Батцэнгэл сумдад тоосгоны үйлдвэрлэлийг, Батцэнгэл, Өндөр-Улаан сумдад шохойн чулууны

ордыг түшиглэн шохойны, цементийн үйлдвэр байгуулах боломжтой байна.

Мөн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг боловсруулах чиглэлээр өндөр уулын бүсийн сумдад сарлагийн хөөвөр боловсруулж бүтээгдэхүүн хийх, байгалийн жимсийг боловсруулан варень хийх савлах үйлдвэр, Эрдэнэмандал суманд ноос угаах, Ихтамир, Чулуут, Хашаат сумдад эсгий эсгий гутлын үйлдвэр, нийт сумдад махны үйлдвэрлэл, сүүг савлах, малчдаас сүү аарцыг авч үйлдвэрийн аргаар цагаан идээ хийх үйлдвэрүүдийг байгуулан ажиллах боломж байна. Мөн байгалийн рашаан цэвэр усыг савлах үйлдвэрийг Эрдэнэбулган болон бусад суманд байгуулах бололцоотой байна.

АШИГЛАСАН НОМ, МАТЕРИАЛ

1. .Аймгийн нийгэм эдийн засгийн 2015 оны эмхтгэл
2. www.1212.mn
4. www.nso.mn
5. www.arkhangai.nso.mn.
6. Аймгийн статистикийн бюллетень 2015 он

_____ о О о _____

Тэмдэглэл